



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 44

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан хугацаанд багтаан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулах ажлыг зохион байгуулахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд даалгасугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж Төрийн ордны барилга байгууламж, нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны танхим, өрөө тасалгааны зохион байгуулалттай холбогдох зураг төсөл, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн өөрчлөлт хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын 3-т заасан арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

5.Энэ тогтоол баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, орон тоо, цалингийн сан, үйл ажиллагааны төсвийн төслийг боловсруулж, шийдвэрлүүлэх;

2/Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллах.

6.Энэ тогтоолыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН  
ӨӨРЧЛӨЛТӨД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ  
НИЙЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

<b>Д/д</b>	<b>Нэр</b>	<b>Хугацаа</b>
1.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган
2.	Улс төрийн намын тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган
3.	Монгол Улсын Төрийн ордны тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган
4.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган
5.	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган
6.	Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон холбогдох бусад хууль	Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган
7.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН  
ДҮНГЭЭР БАЙГУУЛАГДАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ЭХЛЭХЭД ШААРДАГДАХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ  
АЖЛЫН ХЭСЭГ**

**Ажлын хэсгийн ахлагч:**

Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга

**Гишүүд:**

Н.Энхболд -Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Г.Тэмүүлэн -Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд

Д.Амарбаясгалан -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Л.Өлзийсайхан -Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга

Л.Алтангэрэл -Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга

Ж.Тамир -Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга

Г.Ариунбуян -Онцгой байдлын ерөнхий газрын дарга

**Нарийн бичгийн дарга:**

Ц.Батбаатар -Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга